

## ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Төрийн бус байгууллагын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хүрээнд Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо (цаашид "Холбоо" гэх)-ны Дүрэм (цаашид "Дүрэм" гэх)-д заасан этгээдийг гишүүнээр элсүүлэх, түдгэлзүүлэх болон гишүүнээс хасах, гишүүн байгууллагын эрх, үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журмыг Холбооны нийт гишүүд дагаж мөрдөнө.
- 1.3. Холбооны гишүүний хүлээх эрх, үүрэг нь энэ журмаас гадна Гишүүнчлэлийн гэрээ (Хавсралт 4) болон Холбооноос дээрх харилцааг зохицуулахаар баталсан бусад журам, баримт бичгүүдээр зохицуулагдана.
- 1.4. Энэ журмаар зохицуулагдаагүй бусад харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "Хороо" гэх), Холбооноос баталсан журмууд болон холбогдох бусад нийтлэг хууль тогтоомжийг баримтлан зохицуулна.
- 1.5. Холбооны сонгуульт албан тушаалтан энэ журам болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад журам, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

## ХОЁР. ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ, ЭЛСҮҮЛЭХ

### Хүсэлт ирүүлэх

- 2.1. Гишүүнээр элсэх хүсэлтийг Холбооны ажлын алба (цаашид "Ажлын алба" гэх)-д ирүүлнэ.
- 2.2. Холбооны мэргэжлийн гишүүнээр элсэх этгээд дараах бичиг баримтыг бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:
  - 2.2.1. Гишүүнээр элсэх өргөдөл (Хавсралт 1);
  - 2.2.2. Удирдах ажилтнуудын анкет (Хавсралт 2);
  - 2.2.3. Мэргэжлийн байгууллагын 5%-аас дээш хувьцаа эзэмшигчдийн жагсаалт;
  - 2.2.4. Хорооноос авсан Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
  - 2.2.5. Байгууллагын танилцуулга;
  - 2.2.6. Гишүүний элсэлтийн хураамж төлсөн баримт.
- 2.3. Холбооны дэмжигч гишүүнээр элсэх этгээд дараах бичиг баримтыг бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:
  - 2.3.1. Гишүүнээр элсэх өргөдөл (Хавсралт 1);
  - 2.3.2. Удирдах ажилтнуудын анкет (Хавсралт 2);
  - 2.3.3. Мэргэжлийн байгууллагын 5%-аас дээш хувьцаа эзэмшигчдийн жагсаалт;
  - 2.3.4. Хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар (хувь хүн бол иргэний үнэмлэхийн хуулбар);
  - 2.3.5. Байгууллагын танилцуулга (хувь хүн шаардлагагүй);
  - 2.3.6. Гишүүний элсэлтийн хураамж төлсөн баримт.

### Нэмэлт мэдээлэл шаардах, хүсэлтийг буцаах

- 2.4. Ажлын алба дараах нөхцөлд гишүүнээр элсэх хүсэлтийг буцаах, эсхүл нэмэлт шаардлага хүргүүлнэ. Үүнд:

- 2.4.1. Энэ журамд заасан шаардлага хангаагүй бол;
  - 2.4.2. Энэ журамд заасан шаардагдах баримт бичиг нь агуулга болон бүрдэлтийн хувьд зөрчилтэй эсвэл дутуу бол;
  - 2.4.3. Хүсэлт гаргасан этгээд, түүний нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдсан, энэ тухай хүсэлт гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гарсан бол;
  - 2.4.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох журмыг ноцтойгоор зөрчиж байсан, Хорооноос олгосон холбогдох тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон бол;
- 2.5. Хүсэлт гаргагч нь гишүүнээр элсүүлэхээс татгалзсан шийдвэр хүлээн авсан бол энэ тухай Холбооны Хяналтын зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

#### **Гишүүнээр элсүүлэх**

- 2.6. Холбооны гишүүнээр элсүүлэх асуудлыг Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.
- 2.7. Гишүүнээр элсэх хүсэлтийг Ажлын алба хянаж, дараагийн Удирдах зөвлөлийн ээлжит хуралд танилцуулна.
- 2.8. Удирдах зөвлөл өөрөөр шийдвэрлээгүй бол мэргэжлийн болон дэмжигч гишүүнээр элсэх хүсэлтийг хэлэлцэхэд хүсэлт гаргагч байгууллагын Гүйцэтгэх захирал өөрийн биеэр хуралд оролцоно.
- 2.9. Удирдах зөвлөлийн дарга болон Холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Гишүүнчлэлийн гэрээ байгуулснаар Холбооны гишүүний эрх, үүрэг үүснэ.

#### **ГУРАВ. ГИШҮҮНД ТАВИГДАХ ШАЛГУУР**

- 3.1. Холбооны гишүүн нь Дүрэмд зааснаас гадна дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
  - 3.1.1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах аливаа мэдэгдлийг эрх бүхий байгууллагаас аваагүй байх;
  - 3.1.2. Эрх бүхий байгууллагаас тогтоосон үүрэг даалгаврыг биелүүлэхтэй холбоотой аливаа зөрчилгүй байх;
  - 3.1.3. Хууль, журмаар шаардсан тайлан, мэдээг нэгээс доошгүй жилийн хугацаанд эрх бүхий байгууллагад үнэн зөв тайлагнасан байна.

#### **ДӨРӨВ. ХОЛБОО БОЛОН ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ**

- 4.1. Холбооны гишүүн нь Дүрэмд зааснаас гадна дараах эрхтэй. Үүнд:
  - 4.1.1. Холбооны удирдлага, хяналтын зөвлөл, ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой хууль, журмаар хориглоогүй мэдээлэлтэй танилцах.
  - 4.1.2. Холбооны гишүүдийн нийтлэг эрх ашигтай холбоотой санал, гомдол, зөвлөмж ирүүлэх, тэдгээрийн биелэлтийг шаардах;
  - 4.1.3. Холбооноос зохион байгуулж буй аливаа арга хэмжээнд оролцох, хамтран зохион байгуулах;
  - 4.1.4. Холбооны үйл ажиллагаатай холбоотой систем, программ хангамжийг ашиглах, холбогдох, энэ тухай заавар мэдээллээр хангуулах;
  - 4.1.5. Дүрэм, журамд заасан бусад.
- 4.2. Гишүүн нь Дүрэм, энэ журамд заасан эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа хүсэлт, санал, гомдлоо албан бичиг, Холбооны албан ёсны цахим шуудан, программ хангамж ашиглаж ирүүлнэ.
- 4.3. Холбооны гишүүн эрхээ хэрэгжүүлэхдээ бусад гишүүний нийтлэг эрх ашигт нөлөөлөхгүй, ижил тэгш, ил тод байх зарчмыг баримтална.
- 4.4. Холбооны гишүүн нь Дүрэмд зааснаас гадна дараах үүрэгтэй. Үүнд:

- 4.4.1. Холбооны нийт гишүүдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа хараат бус явуулахад болон бизнесийн нэр хүндэд хүндэтгэлтэй хандах зарчим баримтлах;
  - 4.4.2. Гишүүн нь Холбооны гишүүнчлэлийн хураамжийг энэ журамд заасны дагуу төлөх;
  - 4.4.3. Энэ журмын хавсралт 1, 2-т заасан мэдээллийг гишүүнээр элсэхэд, Албан ёсны хаяг, цахим хуудас, лого, цахим шуудан, утасны дугаар, эрхий бүхий мэргэжилтнүүдийн нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаар, цахим шууданг шинэчилсэн бол тухай бүр Холбоонд ирүүлэх.
- 4.5. Гишүүн нь холбогдох хууль, журмаар хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй, Холбооноос илгээсэн мэдээлэлтэй танилцаагүйгээс үүсэх аливаа эрсдэлийг гишүүн бие даан хариуцна.
  - 4.6. Холбоо нь гишүүн байгууллагаас Дүрэм, журамд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
  - 4.7. Холбоо нь Өөрийгөө зохицуулах байгууллагын үүргээ биелүүлэх зорилгоор хууль, журмын хүрээнд гишүүн байгууллагаас мэдээлэл шаардах, шаардлага хүргүүлэх эрхтэй.
  - 4.8. Холбоо нь Төрийн бус байгууллагын тухай хууль болон Дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж, дотоод ардчилал, эрх тэгш, шударга харилцааг эрхэмлэж, гишүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах.
  - 4.9. Холбооны гишүүдийн нэгдмэл байр суурьд тулгуурлан Холбооны гадаад дотоодын харилцааг хөгжүүлж, гишүүдээ төлөөлөх.
  - 4.10. Холбоо нь гишүүдийн нийтлэг эрх, ашгийг хамгаалах зорилгоор гишүүн байгууллагыг мэдээлэл, Холбооны үйл ажиллагаатай танилцах боломжоор хангах;
  - 4.11. Холбоо нь гишүүн байгууллага, тэдгээрийн ажилтнуудын төрийн өндөр, дээд шагнал, салбарын шагналд тодорхойлсон материалыг холбогдох байгууллагат хүргүүлж ажиллана.

#### **ТАВ. ГИШҮҮНИЙ ХУРААМЖ**

- 5.1. Гишүүн нь элсэлтийн хураамж болон жилийн хураамжийг хавсралт 3-т заасны дагуу төлнө.
- 5.2. Гишүүн нь холбооны үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад хэлбэрээр дэмжлэг, туслалцаа үзүүлж болно.
- 5.3. Холбооны гишүүнээс сайн дураар эсвэл Удирдах зөвлөлийн шийдвэрээр хасагдсан тохиолдолд гишүүний хураамжийн талаар нэхэмжлэл гаргах эрхгүй.
- 5.4. Гишүүний хураамж, санхүүгийн дэмжлэг, туслалцааг Холбооны үндсэн үйл ажиллагааны зардалд зарцуулна.

#### **ЗУРГАА. ГИШҮҮНИЙ ХАРИУЦЛАГА**

##### **Мэргэжлийн гишүүний хариуцлага**

- 6.1. Холбооны гишүүн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Дүрэм болон энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Удирдах зөвлөлийн шийдвэрээр дараах хариуцлага ногдуулна. Үүнд:

- 6.1.1. Албан бичгээр сануулах;
  - 6.1.2. Зөрчлийн талаар эрх бүхий байгууллага, олон нийтэд мэдээлэх
  - 6.1.3. Гишүүний эрхийг түдгэлзүүлэх,
  - 6.1.4. Гишүүнийн эрхийг дуусгавар болгох, гишүүнээс хасах.
- 6.2. Тухайн гишүүнтэй холбоотой зөрчил нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол энэ талаар нийт гишүүдэд мэдэгдэнэ.
- 6.3. Хяналтын зөвлөлийн дүгнэлтэд гишүүний гаргасан зөрчлийн үр дагавар, эрсдэлийн тухай мэдээлэл болон хариуцлагын төрлийг тусгасан байна.
- 6.4. Удирдах зөвлөл гишүүнд ногдуулсан хариуцлагатай холбоотой зөрчил бүрэн арилсан тухай тайлбар, нотлох баримтыг үндэслэн гишүүний эрхийг сэргээх шийдвэр гаргана.

## **ДОЛОО. ГИШҮҮНИЙ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ, ДУУСГАВАР БОЛГОХ**

### **Гишүүний эрхийг хязгаарлах**

- 7.1. Удирдах зөвлөлийн шийдвэрээр гишүүний эрхийг хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлаж болно.
- 7.2. Удирдах зөвлөл дараах тохиолдолд гишүүний эрхийг хэсэгчлэн эсвэл бүрэн хязгаарлана. Үүнд:
- 7.2.1. Гишүүний үүргээ биелүүлээгүй гишүүнд Удирдах зөвлөл сануулах алба бичиг хүргүүлэх бөгөөд албан бичигт заасан хугацаанд үүргээ мөн биелүүлээгүй бол хэсэгчлэн;
  - 7.2.2. Хяналтын зөвлөлийн шийдвэрээр гишүүний эрхийг хязгаарлахыг санал болгосон хэсэгчлэн болон бүрэн;
  - 7.2.3. Гишүүн нэгээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй бол бүрэн;
  - 7.2.4. Гишүүний хураамжийг нэгээс дээш жилийн хугацаанд төлөөгүй бол бүрэн.

### **Холбооны гишүүнээс хасах**

- 7.3. Удирдах зөвлөл дараах үндэслэлээр гишүүнээс хасах буюу гишүүний эрхийг бүхэлд нь дуусгавар болгоно. Үүнд:
- 7.3.1. Удирдах зөвлөлөөс ногдуулсан хариуцлагатай холбоотой зөрчлийг заасан хугацаанд арилгаагүй;
  - 7.3.2. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхгүй болсон;
  - 7.3.3. Гишүүн хүсэлт гаргасан.
- 7.4. Гишүүнээс хассан тухай Удирдах зөвлөлийн шийдвэрийг Хороо болон нийт гишүүдэд мэдэгдэнэ.

### **НАЙМ. БУСАД**

- 8.1. Их хурлаас өөрөөр шийдвэрлээгүй бол энэхүү журам нь Хороо батламжилсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

**“МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО”**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,  
Энхтайван өргөн чөлөө  
Экспресс тауэр 11-01  
Утас: 7013-3339

Цахим шуудан: info@masd.mn

Цахим хуудас: www.masd.mn

**ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ӨРГӨДӨЛ**

Хуулийн этгээдийн нэр MN\*: .....

Хуулийн этгээдийн нэр ENG\*: .....

Хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл\*: .....

Хуулийн этгээдийн төрөл\*: .....

Хуулийн этгээдийн РД\*: .....

ХХК:

ХК:

1.1. Хуулийн этгээдийн удирдлага: Гүйцэтгэх захирал\*:

Овог\*: .....

Нэр\*: .....

Гар утас\*: .....

Цахим шуудан\*: .....

1.2. Хуулийн этгээдийн албан ёсны хаяг:

Аймаг/хот\*: .....

Сум/дүүрэг\*: .....

Гудамж/байшин/ хаалганы дугаар\*: .....

Цахим шуудан\*: .....

Цахим хуудас\*: .....

1.3. Гишүүнчлэлийн ангилал\*:

Мэргэжлийн гишүүн

Хамтрагч гишүүн

..... нь Холбооны дүрмийг хүлээн зөвшөөрч, өөрийн сайн  
дураар тус холбооны гишүүн болохыг хүсэлтээ илэрхийлж байна. Холбооны дүрэм,  
журамд заасан эрх, үүргийг сахиж ажиллана.

Өргөдөл гаргасан:

Тамга .....

/Гарын үсэг/

/Нэр/

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УДИРДАХ АЖИЛТНЫ АНКЕТ**



<b>1. Хувийн мэдээлэл:</b>			
Овог:	Нэр:	Төрсөн огноо:	
Гар утас:	Ажлын утас:	Цахим шуудан:	
Гэрийн хаяг:			
<b>2. Боловсролын байдал:</b>			
Сургуулийн нэр	Эзэмшсэн мэргэжил	Элсэн орсон огноо	Төгссөн огноо
<b>3. Ажлын туршлага:</b>			
Байгууллагын нэр	Албан тушаал	Орсон он, сар	Гарсан он, сар

**Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны  
гишүүний хураамж**

№	Хураамжийн төрөл	Гишүүний төрөл	Хураамжийн хэмжээ	Төлөх давтамж
1	Элсэлтийн хураамж	Мэргэжлийн гишүүн	2,000,000 төгрөг	Гэрээ байгуулах үед нэг удаа төлнө
2		Дэмжигч гишүүн	1,000,000 төгрөг	
3	Жилийн хураамж	Мэргэжлийн гишүүн	1,000,000 төгрөг	Жил бүрийн нэгдүгээр хагаст багтаан төлнө
4		Дэмжигч гишүүн	500,000 төгрөг	

## **Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүний гэрээний үлгэрчилсэн загвар**

### **1. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Энэхүү гэрээгээр Холбооны дүрэм, журам салбарын бусад хууль тогтоомжийн хүрээнд Холбоо болон гишүүн байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү гэрээний зорилго нь гишүүн байгууллага Холбооны дүрэм, дотоод журмуудыг сахин биелүүлж, гишүүдийн эрх, үүрэг, сахилга бат, нэгдмэл зохион байгуулалттай үйл ажиллагааг сайжруулж, Салбарын нэр хүндийг өргөн, нийгэм, олон нийтэд нөлөө бүхий Холбоог бий болгох явдал мөн.

### **2. Холбооны эрх, үүрэг**

- 2.1 Холбоо нь өөрийн дүрэм, журамд зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй.
  - 2.1.1. Гишүүдийн үйл ажиллагаанд Холбооны дүрэм, журмыг мөрдүүлэх, түүнтэй холбоотой зөвлөмж, заавар хүргүүлэх;
  - 2.1.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Холбооны дүрэм, журмын хүрээнд хариуцлага тооцох;
  - 2.1.3. Гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, аливаа зөрчил, алдааг арилгахад дэмжлэг үзүүлэх;
  - 2.1.4. Холбооны чиг үүргийн хүрээнд арга хэмжээ зохион байгуулах, түүнд зориулсан хандив тусламж авах;
  - 2.1.5. Гишүүнчлэлийн хураамжийн хэмжээг тогтоох, журамд заасны дагуу нэхэмжлэх.

### **3. Гишүүний эрх, үүрэг**

- 3.1. Гишүүн байгууллага нь Холбооны дүрэм, журамд зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй.
  - 3.1.1. Сонгуульт албан тушаалтнаар дамжуулан Холбооны үйл ажиллагаанд хяналт тавих;
  - 3.1.2. Холбооны үйл ажиллагаа, зохицуулалттай холбоотой мэдээллээр хангуулах;
  - 3.1.3. Холбооны дүрэм, журмууд болон үнэт цаасны зах зээлийн зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах;
  - 3.1.4. Хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүрэг болон Холбооноос гаргасан шийдвэрийг биелүүлэх;
  - 3.1.5. Хууль, дүрэм, журмын төслүүдэд санал өгөх, гишүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа болон Холбооноос зохион байгуулах арга хэмжээнд идэвхтэй оролцох;
  - 3.1.6. Холбооноос түгээсэн аливаа зар, санал асуулгад заасан хугацаанд хариу өгөх;
  - 3.1.7. Холбооны гишүүний хураамжийг төлөх.

### **4. Бусад**

- 4.1 Энэ гэрээний аль нэг заалт хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон нь бусад заалтын

- хүчинтэй байдалд нөлөөлөхгүй.
- 4.2 Энэхүү гэрээ, бусад зохицуулалтыг зөрчсөн этгээд зохих журмын дагуу хариуцлага хүлээнэ.
  - 4.3 Талууд энэ гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд гэрээний хувиуд хууль эрх зүйн хувьд ижил хүчинтэй байна.
  - 4.4 Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно.
    - 4.4.1. Гишүүн байгууллагын сайн дурын хүсэлтийг үндэслэн УЗ-ийн шийдвэр гарсан;
    - 4.4.2. Холбооны дүрэм, журмын дагуу хариуцлага тооцож, УЗ-ийн шийдвэрээр гишүүнээс хассан.

## 1. ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

МҮЦАЭХ-г төлөөлж:

.....

Албан тушаал:

.....

/ ..... /

Цахим шуудан: [info@masd.mn](mailto:info@masd.mn)

Утас: 70123339

Гишүүнийг төлөөлж:

.....

Албан тушаал:

.....

/ ..... /

Цахим шуудан:

Утас:

